



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/104

Улаанбаатар хот

Өмч хамгаалах зөвлөлийг шинэчлэн  
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1, 31.4, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын эд хөрөнгийн хөдөлгөөн болон хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллах үүрэг бүхий "Байгууллагын өмч хамгаалах зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Гишүүд:

Ахлах нягтлан бодогч

Захиргаа, санхүүгийн хэлтсийн Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн  
Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Хот чимэглэл, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн Ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын Агентлаг хариуцсан нярав

Нарийн бичгийн дарга:

Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн /санхүүгийн/

2. Тушаалыг хэрэгжүүлэн ажиллахыг Өмч хамгаалах зөвлөл /Э.Энхцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2017 оны А/247 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  ТГАНТӨМӨР



D:\backup\_old\_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

1110300340